“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”

Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцлийн түүх нь Манж Чин Улсын дарангуйлалд орсноос эхлэн XX зуунд Үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, олон улсаар хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө Монголын үе үеийн эх орончдын явуулсан урт хугацааны тэмцлийн түүх юм. Энэхүү тусгаар тогтнолын төлөө тэмцэл нь 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалаар ялалтад хүрч, 1961 онд НҮБ-ын гишүүнээр БНМАУ элссэнээр бүрэн баталгаажсан юм.

1945 онд хуралдсан Холбоотон гүрнүүдийн тэргүүн нарын Ялтын бага хурлын дараа болсон ЗХУ, ДИУ-ын хэлэлцээрийн явцад хөндөгдсөн гол асуудлын нэг нь БНМАУ-ын тусгаар тогтнолын сэдэв байв. ЗХУ, ДИУ-ын төлөөлөгчид удаан зөвшилцсөний эцэст “…Япон ялагдсаны дараа хэрэв БНМАУ-ын хүн ам тусгаар тогтнох эрмэлзлээ баталбал Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрнө” гэсэн нотыг хоёр тал 1945 оны 8 дугаар сарын 14-нд солилцжээ.

1945 оны 9 дүгээр сарын 21-нд хуралдсан БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 76 дугаар хурлаас “Бүх ард түмний саналыг тус улсын бүх дэвсгэр нутаг дээр 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр нэгэн зэргээр гаргуулах” тогтоол, 10 дугаар сарын 5-нд хуралдсан 85 дугаар хурлаас “Санал хураалтыг явуулах заавар”-ыг тус тус батлан гаргав. Ийнхүү сар хүрэхгүй хугацаанд 4259 санал хураах байр, 3304 санал хураах салбар комиссыг 20138 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулснаар БНМАУ-ын тусгаар тогтнолын төлөө бүх ард түмний санал хураалтын бэлтгэл ажил үндсэндээ дуусч, 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн өглөөний 6 цагт санал хураалт эхэлж, үдшийн 24 цаг хүртэл үргэлжилжээ. Тус санал хураалтад Улаанбаатар хот, 18 аймаг, МАХЦ, Хязгаарын цэрэг, гадаад оронд сурч ажиллаж байсан зэрэг 487.285 сонгуулийн эрх бүхий хүн буюу нийт сонгогчдын 98.6% нь оролцож, бүгд тусгаар тогтнолоо 100 % баталжээ. Мөн 7551 хүн ямар нэгэн шалтгаанаар тусгаар тогтнолын санал хураалтад оролцож чадаагүй байна. Санал хураалтын дүнгийн тухай Төв комиссын тогтоолыг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 100 дугаар хурлын тогтоолоор батлан, 1945 оны 11 дүгээр сарын 10-нд ЗХУ, ДИУ-ын Засгийн газарт илгээжээ.

ДИУ-ын Засгийн газрын төлөөлөгч Лэй Фа Жан тэргүүтэй 12 хүнтэй баг Улаанбаатар хотын 3, 5, 8 дугаар хороо, Төв аймгийн Лүн сумын 1 дүгээр багт санал хураалтад ажиглагчаар оролцож, санал хураалтын дараа төлөөлөгчдийн тэргүүн Лэй Фа Жан МАХН-ын Төв Хороо, Монгол Ард Улсын Засгийн газрын төв хэвлэл “Үнэн” сонинд ярилцлага өгч, 11 дүгээр сарын 1-нд “Гадаад Монголын ард түмний санал хураалтын тухай илтгэл”-ийг ДИУ-ын Ерөнхийлөгч Чан Кай Ши-д өргөн барьжээ. 1946 оны 1 дүгээр сарын 5-нд ДИУ-ын Засгийн газраас БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдлийг гаргажээ. Санал хураах Төв комиссын орлогч дарга Ч.Сүрэнжав тэргүүтэй төлөөлөгчид 1946 оны 2 дугаар сарын 8-нд Чунчинь хотод очиж, санал хураалтын дүнг танилцуулан, ДИУ-ын Засгийн газартай хэлэлцээ хийсний дүнд 1946 оны 2 дугаар сарын 13-нд БНМАУ, ДИУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох, элчин төлөөлөгчөө харилцан суулгах тухай нот бичиг солилцжээ.

Ийнхүү Монгол Улс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу тусгаар тогтносон бүрэн эрхт улс болохоо хөрш зэргэлдээ ЗХУ, ДИУ-аар хүлээн зөвшөөрүүлснээр олон зууны турш тэмцсэн эх орончдын хүсэл биелэлээ олж, дэлхийн улс орнуудтай эрх тэгш харилцах бодит нөхцөл бүрэлдсэн түүхтэй.

ТҮҮХИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АРХИВЫН ГАЗАР МОНГОЛУЛС

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



ЗХУ, АНУ, Их Британий төрийн тэргүүнүүдийн Ялтын хэлэлцээрийн явц. 1945.2. 11



СОВЕРШЕННО СЕКРЕТНО.

СОГЛАШЕНИЕ.

Руководители трех Великих Держав - Советского Союза, Соединенных Штатов Америки и Великобритании -согласились в том, что через два-три месяца после капитуляции Германии и окончания войны в Европе Советский Союз вступит в войну против Японии на стороне Союзников при условии:

1. Сохранения status quo Внешней Монголии (Монгольской Народной Республики);

2. Восстановления принадлежавших России прав, нарушенных вероломным нападением Японии в 1904 г., а именно:

а) возвращения Советскому Союзу южной части о.Сахалина и всех прилегающих к ней островов;

b) интернационализация торгового порта Дайрена с обеспечением преимущественных интересов Советского Союза в этом порту и восстановление аренды на Порт-Артур, как на военно-морскую базу СССР;

с) совместной эксплоатации Китайско-Восточной железной дороги и Южно-Манчжурской железной дороги, дающей выход на Дайрен, на началах организации смешанного Советско-Китайского Общества с обеспечением преимущественных интересов Советского Союза, при этом имеется в виду, что Китай сохраняет в Манчжурии полный суверенитет.



3. Передачи Советскому Союзу Курильских островов.

Предполагается, что соглашение относительно Внешней Монголии и вышеупомянутых портов и железных дорог потребует согласия генералиссимуса Чан Кай-ши. По совету Маршала И.В.Сталина Президент примет меры к тому, чтобы было получено такое согласие.

Главы Правительств трех Великих Держав согласились в том, что эти претензии Советского Союза должны быть безусловно удовлетворены после победы над Японией.

Со своей стороны Советский Союз выражает готовность заключить с Национальным Китайским Правительством пакт о дружбе и союзе между СССР и Китаем для оказания ему помощи своими вооруженными силами в целях освобождения Китая от японского ига.

ЗХУ, АНУ, Их Британий төрийн тэргүүнүүдийн байгуулсан Ялтын хэлэлцээр. 1945.2.11



БНМАУ (Гадаад Монгол)-ын төрийн тусгаар тогтнол ба газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэн үзэхээ илэрхийлж, ДИУ-ын Гадаад явдлын сайд Ван Ши Це-д бичсэн ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В.Молотовын албан захидал. 1945.08.14.



Японыг ялсны дараагаар Гадаад Монгол (БНМАУ)-ын ард түмэн бүх нийтээр тусгаар тогтнолоо батлабал ДИУ-ын Засгийн газар Гадаад Монгол (БНМАУ)-ын төрийн тусгаар тогтнолыг одоо байгаа хилээр нь хүлээн зөвшөөрөхөө илэрхийлэн ДИУ-ын Гадаад явдлын яамны сайд Ван Ши Це-гээс ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В.Молотовт бичсэн албан захидал.1945.08.14.

ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В.Молотов, ДИУ-ын Гадаад явдлын яамны сайд Ван Ши Це нар “Холбоо найрамдлын гэрээ”-нд гарын үсэг зурж байгаа нь. 1945.08.29

Ежедневная красноармейская газета

За нашу Советскую Родину!

СТАЛИНСКИЙ ПИЛОТ

СРЕДА 29 АВГУСТА 1945 г. № 201 (1950)

К ратификации Договора о Дружбе и Союзе и Соглашений между Советским Союзом и Китайской Республикой

ДОГОВОР

о Дружбе и Союзе между Союзом Советских Социалистических Республик и Китайской Республикой

СОГЛАШЕНИЕ

между Союзом Советских Социалистических Республик и Китайской Республикой о Китайской Чанчуньской железной дороге

ЗХУ, ДИУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан “Холбоо, найрамдлын гэрээ”-ний талаар “Сталины нисгэгч” сонинд нийтлэгдсэн мэдээ.1945.08.29

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛ

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТНАМЫН ТӨВХОРООНЫ УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ 1945 ОНЫ 9 ДУГААР САРЫН 25 НЫ ӨДРИЙН 58 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ.

Утга нь : Бүгд Найрамдах Монгол ард улсын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулах тухай.

Бүгд найрамдах монгол ард улсын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулах явдал бол олон нийтийг эрүүл хэмжээгээр ороцуулах талаараа бүгд найрамдах монгол ард улсын тогтнон буй үед намаас явуулж байсан бүхий Кампануудын дотроос хамгийн том зохион байгуулалт , улс төрийн кампань мөн гэж монгол ардын хувьсгалт намын төв хорооны улс төрийн товчооноос үзнэ,

Сонгуулийн эрх бүхий тус улсын бүх хүн амыг толгой дараалан ороцуулж ийнхүү саналыг гаргуулах нь намын байгууллагануудын ажиллагаанд урид тохиолдож байгаагүй зохион байгуулалт , улс төрийн ажлын том хэмжээний агуу их сургууль мөн .

Ийнд энэхүү санал гаргуулах кампаниг ажилтайгаар гүйцэтгэхийн тулд намын бүх байгууллага, намын бүх гишүүд, нам бус олон нийтийн байгууллагануудаас мөнхүү санал гаргуулах тухайн бэлтгэлийг хийж уул ажлыг хангахад зохион байгуулах , тайлбарлан таниулах шаргуу ажиллага иход шаардагдна.

Бүгд найрамдах монгол ардын улсын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулах ажлыг зохион ~~байгуулна~~ байгуулалтайгаар цаг тухайд нь хангах түүнд тус улсын сонгуулийн эрх бүхий ард иргэдийг нийтээр нь дүүрэн ороцуулах зорилгоор монгол ардын хувьсгалт намын төв хорооны улс төрийн товчооны хуралаас тогтоох нь :

- 2 -

1. Эн санал гаргуулах кампанийг зохион байгуулж гүйцэтгэх тухай бүхий ажлыг удирдуулахын тулд түүнийг эрхэлсэн төв комиссыг доор дурьдсан бүрэлдүүнтэйгээр байгуулахыг бага хурлын төргүүлэгчдэд даалгах үүнд: Комиссын даргад нөхөр Бумцэнд, орлогчид нь нөхөр Сүрэнжав , гишүүд нь, Янжмаа, Шириндив, Лувсан , Үйлдвэрчний төв зөвлөлийн Базарсад , Эвлэлийн төв хорооны Рагчаасүрэн , Ардын хувьсгалт цэргийн Равдан, Хлэгаарын цэргийн Санжаа нар ба мөн санал гаргуулах ажлыг эрхлэх аймгийн комиссуудын дарга нараар томилогдох аймгийн намын хороодын нэгдүгээр нарийн бичгийн дарга нарыг тус тус томилох үүнд:

Чойбалсан аймгаас Тогмид, Сүхбаатар аймгаас Норовсамбуу, Дорноговь аймгаас Чойжанц, Хэнтий аймгаас Гунгаажав , Төв аймгаас Ядамсүрэн, Өмнөговь аймгаас Багаажав, Дундговь аймгаас Эрэнцэндорж, Өвөрхангай аймгаас Даждин , Сэлэнг аймгаас Даваг , Булган аймгаас Даждин, Хөвсгөл аймгаас Гүнтовсүрэн ,Завхан аймгаас Дугэржав, Архангай аймгаас Банзрагч, Баянхонгор аймгаас Лаажав , Говь- Алтай аймгаас Ламчин, Ховд аймгаас Балжар , Увс аймгаас Намжилдорж Баян - Өлгий аймгаас Хэшгэнбай, Улаан - Баатар хотоос Сосорбарам, нарыг ороцуулан байгуулсугай.

2. Энэхүү санал гаргуулах явдлыг аймаг хот, сум , хороо, баг , хорьдод зохион байгуулж гүйцэтгэх тухайн ажлыг удирдуулахын тулд иймхүү санал гаргуулах ажлыг эрхэлсэн аймаг, хот , сум , баг , хороо, хорьдын комиссуудыг доор дурьдсан бүрэлдүүнтэйгээр байгуулах үүнд:

Аймаг Хотуудын комиссын даргад төв комиссын гишүүнд багтсан намын хороны нэгдүгээр нарийн бичгийн

- 3 -

дарга , гишүүдэд аймаг хотын захиргааны дарга, үйлдвэрчний зөвлөлийн дарга , эвлэлийн хороны ~~б~~ дарга , аймаг хотын эмэгтэйчүүдийн зохион байгуулагч нарыг ороцуулан байгуулна.

Сумдын комиссын даргад намын үүрийн дарга бүх сумын захиргааны дарга, гишүүдэд сумын захиргааны дарга байвал зохих бөгөөд хэрэв ~~сумын~~ сумын дарга комиссын дарга байвал , намын үүрийн дарга комиссын гишүүн болон ороцно.

Суман комиссын бусад гишүүдэд эвлэл, үйлдвэрчний үүрийн дарга нар сумын эмэгтэйчүүдийн зохион байгуулагч , ардуудын дотроос хөдөө итгэмжтэй нар байцна.

Багийн комиссын даргад багийн захиргааны дарга , гишүүдэд нам , эвлэлийн гишүүн тус бүр нэг , багийн орлогч дарга, ардуудаас хөдөө хүнийг тус тус ороцуулан бүрэлдүүлбэл зохино.

Санал гаргуулах кампаниг явуулах журмын тухай заавры боловсруулан нийтлэхийг улсын бага хурлын төргүүлэгчдэд дурьдсугай.

4. Санал гаргуулах кампаньд бэлтгүүлэх , түүний учир зорилгыг таниулах , түүнийг явуулах журмыг тайлбарлах ба мөн түүнчлэн сонгуулийн эрх бүхий ард иргэдийг ийнхүү санал гаргуулах явдалд бүрэн ороцуулах талаар тайлбарлан таниулах ажлыг эрхэмсэн ханган явуулыг аймаг хотын намын хороо, үүрүүд ба эвлэлийн төв хороонд үүрэг болгосугай.

5. Санал гаргуулах кампанийн учир зорилого болон бүрэн эрхтэй тусгаар тогтнох гэгч нь чухам юу болох ба түүний ач холбогдол мөн түүнчлэн бүгд найрамдах монгол ард улсын тусгаар тогтносон 25 жилийн дотор

- 4 -

олсон ~~ажилтнууд~~ ажилтнууд , бүгд ~~ай~~ найрамдах монгол ард улсын ард иргэдийн эрх үүрэг , ~~ард~~ тус улсын хөдөлмөрчин олны хувьсгалын өмнөх эрх чөлөөгүй байдал ба мөн Японы түрэмгийлэн эзлэгчидээс чөлөөлөгдсөн районууд дахь дотоод монголчуудын эрх чөлөөгүй байдлын тухай илтгэл ярих хигчидэд зориулсан сэдэвчүүдийг энэ 9 дүгээр сарын 25 ны наана бэлтгэн нийтлэхийг намын төв хорооны сурвалж хэлтэсд даалгасугай.

Дээр дурьдсан агуулгаа бүхий хэд хэдэн хилбарчилсан статьяа үгүүлэлийг сонин хэвлэлд нийтлэх ба мөн түүнчлэн тус улсын ард иргэдийг санал гаргуулах ажилд толгой дараалан ороцохыг уриалсан лоозон хуудас зурагуудыг хүрэлцэх хэмжээгээр хэвлэн гаргасугай.

Улс төрийн товчооны гишүүд. ((Чойбалсан)) ((Цэдэнбал)) ((Янжмаа)) ((Бумцэнд)) ((Сүрэнжав)) ((Дамба)) ((Лхавагсүрэн))

Орлогч гишүүд.

Гэрмаа цохилоо,

Уг эхийг ушсан (Надмид)
хараж нийлсэн (Бадгуудай)

“БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулах тухай” МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 58 дугаар хурлын тогтоол. 1945.09.25.

МУУТА. УТНОНББА. Х.4. Д.12. ХН.17. Тал 110



“Улаанбаатар хот ба 18 аймгийн комиссыг байгуулах тухай” БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал хураах ажлыг удирдах Төв комиссын хуралдсан нэгдүгээр хурлын тогтоол. 1945.09.26.

МУУТА. ТБА. Х.11. Д.1. ХН.744. Тал 9



БНМАУ-ын Тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал хураах ажлыг удирдах Төв комиссоос аймаг, хотын комиссуудад өгсөн заавар. 1945.10.03.

МУУТА. УТНОНББА. Х.4. Д.12. ХН.273. Тал 3.

“Монголын ард түмэн бат нэгдэлтэйгээ дэлхий дахинаа үзүүлэх гэж байна”, “БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай 10 дугаар сарын 20-ны өдөр нийслэл Улаанбаатар хотын дотор хэчнээн газар гарын үсэг зурах тухай хуваарилсан төлөвлөгөө”

“Үнэн” сонин. 1945.10.11, №233 (3096),

“Монголын хөдөлмөрчин ардууд төрийнхөө тусгаар тогтнолыг мохошгүй чин зоригтойгоор батлах гэж байна”. Тэргүүн өгүүлэл.

“Үнэн” сонин. 1945.10.13, №235 (3098)

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай ард түмний санал гаргуулах ажлыг эрхлэх Улаанбаатар хотын салбар комиссын ажлын төлөвлөгөө. 1945.10.03.

МУУТА. ТБА. Х.11. Д.1. ХН.744. Тал 134-136



БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 76 дугаар хурлаас гаргасан “Бүх ард түмний саналыг тус улсын бүх дэвсгэр нутаг дээр 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр нэгэн зэргээр гаргуулах” тухай тогтоол ба зааврууд. 1945.09.21

МУУТА, ТБА, Х-11, Д-1, ХН-743

БНМАУ-ын тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтад нам, Засгийн удирдагчид болон Монгол ардын хувьсгалт цэргийн албан хаагчид саналаа өгч буй нь. 1945.10.20

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



Монгол Улсын тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал гаргуулах ажлын явц байдлын талаар Хэнтий аймагт ажилласан Засгийн газрын төлөөлөгч Л.Мажигаас БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсанд илтгэсэн тайлан илтгэл.1945.10.15.

МУУТА. ТБА. Х.1, Д.3, ХН.403, Х.32-33



Сүхбаатар, Чойбалсан /Дорнод/ аймагт тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал гаргуулах ажлыг хариуцан ажилласан Улсын Бага Хурлын тэргүүлэгч гишүүн, Засгийн газрын төлөөлөгч Н.Янжмаагийн Монгол Улсын тусгаар тогтнолын тухай санал гаргуулах ажлыг эрхэлсэн Төв комисст илтгэсэн тайлан илтгэл. 1945.10.24.

МУУТА. ТБА. Х.1, Д.3, ХН.403, Х.15-16

БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал хураалтын үйл явц.1945.10.20



БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай асуудал нэгэнт шийдэгдсэн хэмээн үзэж, Бүх ард түмний санал гаргуулах ажлыг эрхэлсэн Төв комиссоос илтгэсэн “БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний саналыг хураасан дүнгийн тухай протокол”.1945.10 сар.

МУУТА. ТБА. Х.11, Д.1, ХН.746, Х.77-82





БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлаар бүх ард түмний санал хураалтад оролцсон Монгол Улсын харьяат, ЗХУ-ын Калинины Цэргийн дунд сургуулийн сонсогчдын бүртгэл. 1945.11.19.

МУУТА. ТБА. Х.11, Д.1, ХН.745, Х.148

ЗХУ-ын нутаг дэвсгэрийн хэмжээнд сургуульд суралцаж буй ба бусад аль нэгэн хэргээр оршин амьдарч буй Монгол Улсын харьяат бүгд 336 хүмүүсийн саналын хүснэгтийг эмхэтгэн хүргүүлж буйгаа мэдэгдэж, БНМАУ-аас ЗХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрх барих Элчин сайд Ж.Самбуугаас БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Монгол Улсын тусгаар тогтнолын тухай санал гаргуулах ажлыг эрхэлсэн Төв комиссын дарга нөхөр Г.Бумцэндэд бичсэн 100 дугаар албан захидал. 1945.11.19.

МУУТА. ТБА. Х.11, Д.1, ХН.745, Х.158

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



“Тусгаар тогтнолын төлөө бүх ард түмний санал хураалтын ажлын явцын тухай” БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Монгол Улсын тусгаар тогтнолын тухай санал гаргуулах ажлыг эрхэлсэн Төв комиссын дарга нөхөр Бумцэндээс радиод өгсөн ярилцлага. 1945.10.20.

№	Аймгийн нэр	Сумын тоо	Санал өгөвөө зохих хүмүүс	Саналаа өгөх жинхэнэ оролцсон хүмүүс	Үүний дотроос		Сонгуулийн эрх бүхий ард иргэдэд санал хураах өдөрт нийт оршин суугаа, нутаг байгаа хүмүүс	Санал хураах өдөр эрдэм ба хувийн хэргээ яваа буй учир оф саналаа өгөөгүй хүмүүс
					Баталгаа хэд	Баталгаагүй хэд		
1	Сэлэнгэ	10	11571	11974	11974	-	1536	1939
2	Булган	17	23442	21858	21858	-	1681	97
3	Төв	23	37325	36434	36434	-	6150	5259
4	Дорноговь	17	13676	12751	12751	-	1024	99
5	Хөвсгөл	23	35625	36329	36329	-	1107	1811
6	Сүхбаатар	15	17472	17337	17337	-	380	245
7	Чойбалсан	15	22017	19711	19711	-	2435	129
8	Өмнөговь	12	12877	12266	12266	-	1283	672
9	Архангай	23	36242	35579	35579	-	2081	1418
10	Баянхонгор	19	24040	24117	24117	-	197	274
11	Өвөрхангай	22	29105	30133	30133	-	1651	2679
12	Дундговь	18	17877	15404	15404	-	2731	258
13	Хэнтий	21	25909	22698	22698	-	4690	1479
14	Увс	16	26273	25894	25894	-	584	205
15	Ховд	14	21124	21854	21854	-	-	730
16	Баян-Өлгий	12	16777	16025	16025	-	1	249
17	Завхан	23	35833	35323	35323	-	1903	1443
18	Говь-Алтай	17	20703	20147	20147	-	2270	1714
19	Улаанбаатар	9	22616	24865	24865	-	1986	4235
20	Ардын хувьсгалт цэрэг	-	33838	35608	35608	-	35	1805
21	Дотоод яам	-	9337	9533	9533	-	27	223
22	СССР-т буй хүмүүс	-	395	395	395	-	-	-
	ДҮН	**326**	**494074**	**487285**	**48295**	**-**	**33752**	**26963**



БНМАУ-ын тусгаар тогтнолыг ДИУ-ын Засгийн газраас зөвшөөрөн хүлээсэн тухай БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, маршал Х.Чойбалсангийн мэдэгдлийг сонсоод “Аж ахуй, соёл, боловсрол, батлан хамгаалах зэргийн бүх салаа салбарт амжилт гаргахыг тус улсын бүх ард түмэнд уриалсан” БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөл, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид, МАХН-ын Төв Хорооны хамтарсан тогтоол. 1946.01.10

МУҮТА, ТБА, Х-11, Д-1, ХН-746, Х.100-102



БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай 18 наснаас дээш сонгуулийн эрх бүхий ардын санал хураалтын эцсийн дүнг улсын хэмжээнд нэгтгэн гаргасан хүснэгт. 1945.10.25.

МУҮТА, ТБА, Х-11, Д-1, ХН-744, Х.78



Монгол Улсын тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал хураах ажлыг удирдах Төв комиссоос гаргасан “БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар нийтийн саналыг гаргуулсан дүнгийн тухай” тогтоол.1945.11.10

МУҮТА, ТБА, Х-11, Д-1, ХН-744, Х.103-109



БНМАУ-ын БАГА ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
1945 ОНЫ 11-р САРЫН 12-НЫ ӨДРИЙН 100-р
ХУРЛЫН ТОГТООЛ

"БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар саналыг гаргуулсан ажлын дүнгийн тухай"

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдээс тогтоох нь:

Нэг.1945 оны 10-р сарын 20-ны нийтийн санал хураасан дүнгийн тухай Төв комиссын тогтоолыг БНМАУ-ын ард түмнээс тогтнолын тусгаар тогтнолын тухай гаргасан эрилзлийг биелэлсэн бөгөөд бичиг гэх үзэх биелэсүгэй.

Хоёр.Төв комиссын тогтоолыг хэвлэн нийтлэхдэ 1945 оны 8-р сарын 14-ны Зөвлөлийн зөвшөөрөл нийтлэхдэ хурлыг бүгд найрамдах холбоот улсын гадаад явдлын ардын комиссар нөхөн В.М.Молотовт Дундад иргэн улсын гадаад явдлын яамны сайд нөхөн Ван ши-цзе-гээс ирүүлсэн нот бичгийн ёсоор, Дундад иргэн улсын засгийн газраас БНМАУ-ыг тусгаар тогтносон улс гэж зөвшөөрөн хүлээх эрхтэй ёсны бөгөөд, зөвлөлийн засгийн нийтлэн хурлыг бүгд найрамдах холбоот улс бо Дундад иргэн улсын засгийн газарт тус тус явуулсугай.

Гурав.БНМАУ-ын ард иргэдэд сонгуулийн хуралдаан ирүүлсэн бүх баяр, зохидал, шаардлагыг монголын ард түмэн,тогтнолын тусгаар тогтнолтой бойх мохоогүй хүслийг гаргаж бойгаа бөгөөд бичиг гэх үзэх, тов комиссын хуссан ёсоор Сүхбаатарын музейд шилжүүлсүгэй.

Дөрөв.Сонгуулийн хуралдаан тов бо орон нутгийн комиссуудаас зориулсан зааварчилгаа гүйцэтгэсний тэмдэглэл, иссгдсэн үүрэг нь нэгэнт гүйцэтгэсэн учир, дурдсан комиссуудыг тарасугай.

“БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар саналыг гаргуулсан ажлын дүнгийн тухай” БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 100 дугаар хурлын тогтоол. 1945.11.12

МУҮТА, ТБА, Х-11, Д-1, ХН-746, Х.74-75

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



1921 оны Ардын хувьсгалын партизан, Дотоод явдлын яамны Аюулаас сахин хамгаалах газрын ажилтан, дэслэгч Лувсанпэрэнлэйгээс “БНМАУ нь 25 жилийн дотор эх орон тусгаар тогтнолынхоо төлөө гадаад, дотоодын янз бүрийн дайснуудтай шударга ардын хувьд тэмцсээр өөрийн улсын тусгаар тогтнолоо бэхжүүлж чадлаа” хэмээн МАХН-ын Намын Төв Хороонд бичсэн баярын илэрхийлэлт.

МУУТА. УТНОНББА. Х.4. Д.12. ХН.269. Тал 39



“Өнөөдөр би БНМАУ-ын тусгаар тогтнолыг батлахад оролцож байгаа минь юутай гайхамшигтай, юутай сайхан хөгжилтэй, баясгалантай билээ” хэмээн Улаанбаатар хотын 2 дугаар хорооны 10 дугаар хорины ард, эмэгтэй Аюуш овогтой Өлзийжаргалын тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтад оролцсон тухай илэрхийлэлт.

МУУТА. УТНОНББА. Х.4. Д.12. ХН.69. Тал 43



Ч.Лхамсүрэн. “Төрийн тусгаар тогтнолыг батална би” шүлэг “Үнэн” сонин. 1945.10.19, №240 (3103)

Б. Цэдэндорж “Тусгаар тогтнолоо баталмой” шүлэг.

МУУТА. УТНОНББА. Х.4. Д.12. ХН.269. Тал 121



ОРОН БҮХНИЙ ПРОЛЕТАРИ НАР НЭГДЭГТҮГ

Хөдөлмөр

1945 13 №70

МАНАЙ ЭХ ОРНЫ ТУСГААР ТОГТНИЛЫН ТӨЛӨӨ БАТЛАГТАН! МАНАЙ ТУСГААР ТОГТНИСОН ЭРХ ЧӨЛӨӨТ ЭХ ОРОН МАНДТУГАЙ!

Ховд аймгийн Намын хорõ ба Захирганы сонин.

“Ард бүхэн гагцхүү “батална” гэсэн асуулт дээр нэрээ бичихээр бэлтгэж байна” тэргүүн өгүүлэл.

“Хөдөлмөр” сонин 1945.10.13, №70

ОРОН БҮХНИЙ ПРОЛЕТАРИ НАР НЭГДЭГТҮГ

ҮНЭН

1945 20 № 241 (3104)

“Манай ард түмний их баяр” тэргүүн өгүүлэл

“Үнэн” сонин. 1945.10.20, №241 (3104)

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”

БНМАУ-ын Тусгаар тогтнолын төлөө бүх ард түмний санал хураалтыг ажиглахаар ирсэн ДИУ-ын Засгийн газрын төлөөлөгчид. 1946. 10 сар.

МУҮТА, ТБА, Х-11, Д-1, ХН-746, Х.17



БНМАУ-ын Тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтыг ажиглахаар ирсэн ДИУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийн нэр, албан тушаалын жагсаалт. 1945.10.19.

МУҮТА, ТБА, Х-11, Д-1, ХН-746, Х.18.

БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, маршал Х.Чойбалсан тус улсад Тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтыг ажиглахаар ирсэн ДИУ-ын Засгийн газрын Лэй Фа Жан тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалтын тэмдэглэл. 1945.10.23

ГХТА, Х-5, Д-2, ХН-2, Х.29-32



БНМАУ-ын Тусгаар тогтнолын тухай Монголын ард түмний санал хураахаар байгуулагдсан Төв комиссын дарга Г.Бумцэндээс ДИУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийн тэргүүн Лэй Фа Жанд санал хураах ажлын дүнг мэдэгдсэн бичиг.1945.10.22.

МУҮТА, УТНОНББА, Х-4, Д-12, ХН-275, Х.141-145



БНМАУ-ын Тусгаар тогтнолын төлөө бүх ард түмний санал хураалтыг ажиглахаар ирсэн ДИУ-ын Засгийн газрын Лэй Фа Жан тэргүүтэй төлөөлөгчдийг Төв аймгийн Лүн суманд ирэхэд зохион байгуулсан хурдан морины уралдаанд түрүүлж, айрагдсан морьдын бүртгэл. 1945.10.20

ГХТА, Х-5, Д-2, ХН-2, Х.22



БНМАУ-ын Тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтыг ажиглахаар ирсэн ДИУ-ын Засгийн газрын төлөөлөгч Лэй Фан Жантай “Үнэн” сонины эрхлэгч Ц.Дамдинсүрэнгийн хийсэн ярилцлага.

МУҮТА, ТБА, Х-11, Д-1, ХН-746, Х.67-70

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, маршал Х.Чойбалсан Тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтын талаар ДИУ-ын төвийн сонины сурвалжлагч, ноён Лү Жанд өгсөн ярилцлага.

МУУТА. ТБА. Х.11. Д.1. ХН.746. Тал 58.



Тусгаар тогтнолын төлөө бүх ард түмний санал хураалтыг урьдчилан явуулах боломжгүй бөгөөд саналын дүн болон санал хүргэх төлөөлөгчийг 1945 оны 11 сарын эхээр ДИУ-ын Чүнчинь хотноо явуулахаа илэрхийлсэн БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, маршал Х.Чойбалсангаас ЗХУ-аас БНМАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.Н.Ивановт бичсэн 189 тоот албан бичиг. 1945.09.13.

МУУТА. ТБА. Х.1, Д.3. ХН.334. Тал 32-34.



Хятадын Коммунист намын төв байгууллагын “Цзе Фан жибао” сонинд нийтлэгдсэн “БНМАУ-ын тусгаар тогтнолд баяр хүргэсэн нь” хэмээх нэртэй өгүүллийн орчуулгын эх ноорог. 1945.10.29.

МУУТА. ТБА. Х.1. Д.3. ХН.403. Тал 46-54



БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөд албан ёсны баримт болгож “Монгол Улсын тусгаар тогтнолын тухай санал гаргуулах ажлыг эрхэлсэн Төв комиссын тогтоол”-ыг ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В.М.Молотовт хүргүүлснийг мэдэгдсэн БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, маршал Х.Чойбалсангийн албан захидал. Уг захидалд дээрх тогтоолыг ДИУ-ын Гадаад явдлын яамны сайд Ван Ши-Це-д мөн адил хүргүүлснийг мэдэгджээ. 1945.11.13.

МУУТА. ТБА. Х.11. Д.1. ХН.746. Тал 83



ДИУ-ын Засгийн газрын хүсэлтийн дагуу “БНМАУ-ын Тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтын дүнг танилцуулахаар Засгийн газрын төлөөлөгч томилох тухай” МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 61 дугаар тогтоол. 1945.10.26.

МУУТА. УТНОНББА. Х.4. Д.12. ХН.17. Тал 129.

Монгол Улсын Тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтын дүнг танилцуулж, ДИУ-тай дипломат харилцаа тогтоох хэлэлцээр хийх Засгийн газрын төлөөлөгчид явуулах тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 7 дугаар хурлын тогтоол. 1946.01.26.

МУУТА, ТБА. Х.11. Д.1. ХН.746, Тал 108-109



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН 1946 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 24 НӨ ӨДРИЙН 7 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ.

Тус Улсын засгийн газрын төлөөлөгчийг Бүгд найрамдах Дундад Улсад одуулах тухай.

Ардын Сайд Нарын Зөвлөлөөс тогтоох нь.

Нэг. Бүгд Найрамдах Дундад Улсын засгийн газраас манай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн тусгаар тогтнолыг зөвшөөрөн хүлээсэн тухай албан ёсаар мэдэгдсэн явдлыг тохиолдуулан:

1. 1955 оны 10 дугаар сард тус Монгол Ард Улсад Бүгд Найрамдах Дундад Улсын Засгийн газрын төлөөлөгч Ноён ЛИ - БА - ЖАН гийн хүрэлцэн ирснийг харуу очилт болгон тус Улсын Ерөнхий Сайдын орлогч Сайд бөгөөд мал аж ахуйн яамны сайд нохер Чимэддоржийн Сүрэнжавийг тус улсын засгийн газрын төлөөлөгчөөр Бүгд Найрамдах Дундад Улсад одуулсугай .

2. Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Бүгд Найрамдах Дундад Улс хоёрын хооронд дипломат харилцаа байгуулах тухай Бүгд Найрамдах Дундад Улсын Засгийн газартай хэлэлцээ хийх эрхийг нохер Чимэддоржийн Сүрэнжавд олгосугай .

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР МОНГОЛ УЛС

“БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ-1945: баримт, судалгаа”



ДИУ-ын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг 1946 оны 1 дүгээр сарын 5-нд хүлээн зөвшөөрсөн тухай 1946 оны 1 дүгээр сарын 7-ны 10 цагт Чүнчинь хотын Дай Юаний радиогоор уламжилсан мэдээний эх

МУУТА. ТБА. Х.1. Д.3. ХН.403. Тал 1



Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөө зарлан мэдэгдэхээ илэрхийлэн ДИУ-ын Гадаад явдлын яамнаас БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, маршал Х.Чойбалсанд ирүүлсэн нот бичиг. 1946.01.12.

МУУТА. ТБА. Х.11. Д.1. ХН.746. Тал 107.

БНМАУ-ын тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтын дүнг ДИУ-ын Засгийн газарт танилцуулахаар Засгийн газраас томилогдсон Ч.Сүрэнжав тэргүүтэй төлөөлөгчид. /урд эгнээ зүүн гар талаас Лхамсүрэн, Ч.Сүрэнжав, Норовсамбуу, Дордог арын эгнээний зүүн гар талаас Ням, Цэдэв, Бат-Очир, Ринчинсоном/ 1946 он.

ГХТА-ын сан хөмрөгөөс

БНМАУ-ын Тусгаар тогтнолын бүх ард түмний санал хураалтын дүнг ДИУ-ын Засгийн газарт танилцуулж, дипломат харилцаа тогтоох хэлэлцээр байгуулахаар очсон БНМАУ-ын Засгийн газрын Ч.Сүрэнжав тэргүүтэй төлөөлөгчдийг ДИУ-ын Чүнчинь хотоос үдэн гаргаж байгаа нь. 1946. 2 сар.

ГХТА-ын сан хөмрөгөөс













БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгчидтэй уулзсан ДИУ-ын гадаад, дотоодын сонины сурвалжлагч нарын бүртгэл, нэрийн хуудсууд. 1946.02.16.

ГХТА. Х.5. Д.2. ХН.15. Тал 56-57.

36 дугаар оны 1 сарын 16-ны өдрийн 11.30 минутанд хүлээн авав. 2 цагийн дотор хүргэсүгэй. Гадаад Монголын ард түмний санал гаргуулах ажлыг эрхэлсэн Бага хурлын дарга ноён Бумцэндэд. Цааш ноён Чойбалсанд уламжламуй. Урьд та нараас хүлээн авсан цахилгаан мэдээний дотор Гадаад Монголын ард түмэн 34-р он 10-р сарын 20-ны өдөр олон түмний санал хураасны дүнд Гадаад Монголын ард түмэн өөрсдийн тусгаар тогтнох явдлыг нэгэнт баталжээ. Энэ тухай манай Засгийн газрын Улсыг батлан хамгаалах товчооны шийдвэрээр энэ өдөр манай Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг батлан хүлээвэй. Үүнийг Та хоёр ноёдод цахилгаанаар мэдэгдэе. Дотоод явдлын яам. Хятад улсын 35 он 1 сарын 5-ны өдөр.

Гадаад Монголын ард түмэн өөрсдийн тусгаар тогтнох явдлыг нэгэнт баталсан тулд ДИУ-ын Засгийн газар Батлан хамгаалах товчооны шийдвэрийн дагуу Гадаад Монголын тусгаар тогтнолыг баталсныг БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд Гадаад явдлын яамны сайд, маршал Х.Чойбалсан, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Монгол Улсын тусгаар тогтнолын тухай санал гаргуулах ажлыг эрхэлсэн Төв комиссын дарга нөхөр Г.Бумцэнд нарт мэдэгдсэн ДИУ-ын Дотоод явдлын яамны цахилгаан мэдээ.1946.01.16

ГХТА. Х-5, Д-2, ХН-11, Х.36-40